

**Монгол улсын хүний гавъяат эмч, АШУ-ны доктор, профессор,  
МАУА-ийн гишүүн Т.Эрхэмбаатарын нэрэмжит оны “шилдэг  
судлаач” эмч шалгаруулах МЭБЭЭНХ-ны болзол**

2019 оны 11 дүгээр сарын 4

**Зорилго:** Төв, хөдөөд ажиллаж буй эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлийн эмч, эрдэм шинжилгээний ажилтан, их дээд сургуулийн багш нарын судалгааны ажлын чанар, түвшинг дээшлүүлэх, эрдэм судлалын онол практикийн нэгдлийг хангах, залуу судлаачдыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой.

**Шалгаруулах болзол:**

1. Гадаад дотоодод хэвлүүлсэн мэргэжлийн ном, товхимол, сурах бичиг
2. Гадаад дотоодод хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл
3. Гадаад дотоодод хэвлүүлсэн илтгэл / ханын, цахим бусад хэлбэр хамаарна/
4. Гадаад дотоодын эрдэм шинжилгээний хуралд аман илтгэлээ хэлэлцүүлсэн байдал
5. Гадаад дотоодод хэвлүүлсэн эмчийн зөвлөгөө, танин мэдэхүйн зөвлөмж болон бусад хэлбэрийн сурталчилгаа
6. МЭБЭЭНХ болон салбар зөвлөлийн ажилд идэвх санаачлагатай оролцсон байдал

**Ирүүлэх материал:**

1. Шагналд нэр дэвшигчийн товч анкет
2. Сүүлийн 3 жилээр дээрх болзолуудын талаар хийсэн ажлыг тусгасан тайлан
3. Ном, товхимол, сэтгүүл, эмхэтгэлийн нэрийн дүрсжүүлсэн хуулбар, өгүүлэл, илтгэл, зөвлөлмжийг хэвлүүлсэн сэтгүүл, эмхэтгэлийн он, хуудас, хамтран оролцогчийн нэр зэргийг хавсаргасан байх
4. Салбар зөвлөлийн хурлын тэмдэглэл
5. Албан байгууллагын даргын тодорхойлолт

**Шалгаруулалт:**

Шилдэг судлаач эмчийн шагнал олгох Т.Эрхэмбаатар болон МЭБЭЭНХ-ны ажлын хэсэг ирүүлсэн материалуудыг үндэслэн шилдэг судлаач эмчийг шалгаруулж, Удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлнэ.

МЭБЭЭНХ